



**ХАРИЛЦАА ХОЛБООНЫ  
ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ**

2024 оны 05 сарын 16 өдөр

Дугаар 120

Улаанбаатар хот

Сонгон шалгаруулалт зарлах тухай

Радио долгионы тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1.2, 51.1.11 дэх заалт, Зөвшөөрлийн тухай хуулийн 5.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2023 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн А/42 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Үндэсний радио давтамжийн хуваарилалтын хүснэгт”, Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын даргын 2020 оны А/45 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Монгол Улсад Дараа үеийн хөдөлгөөнт холбооны системийг нэвтрүүлэхэд баримтлах бодлогын чиглэл”, Харилцаа холбооны зохицуулах хорооны 2023 оны 106 тоот тогтоолын хавсралтаар батлагдсан “Дараа үеийн хөдөлгөөнт холбооны системд ашиглах радио давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн нөхцөл, шаардлага” баримт бичгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Радио давтамжийн 2595-2615 МГц-ийн 20 МГц зурвасыг ДҮХХ-ны системд ашиглах тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалт”-ыг зарласугай.
2. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан сонгон шалгаруулалтын баримт бичгийг боловсруулж батлуулах, сонгон шалгаруулалтыг зохион байгуулах үнэлгээний ажлын хэсэг байгуулах, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг тус Хорооны дарга /Г.Чинзориг/-д үүрэг болгосугай.

ДАРГА

Г.ЧИНЗОРИГ

ГИШҮҮД

Ч.ЗОЛБАЯР

А.ЛУВСАН-ОЧИР

Н.МАНДАХБААТАР